



МАСКАА ЗҮҮЕ



ГАРАА УГААЯ



ЗАЙГАА БАРЬЯ



УСНЫ САЛБАРЫН ЭРГЭН ТОЙРОНД



Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№2 (04)

2021.01.25

ҮЙЛДВЭРҮҮДИЙН УДИРДЛАГУУД АРИУТГАХ ТАТУУРГЫН СҮЛЖЭЭНД MNS 6561:2015 СТАНДАРТЫН ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БОХИР УС НИЙЛҮҮЛЭХЭЭ МЭДЭГДЭВ



Ус сувгийн удирдах газрын удирдлагууд 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбооны тэргүүн Д.Баярсайхан болон гишүүн байгууллагуудын удирдлагуудыг хүлээн авч уулзлаа. Уулзалтаар Төв цэвэрлэх байгууламжид үүсч байгаа хүндрэл бэрхшээл, арьс ширний үйлдвэрүүдийн технологийн хаягдал усны бохирдлыг бууруулах арга зам, Засгийн газрын 73 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар ярилцаж санал солилцов. Уулзалтын үр дүнд үйлдвэрүүдийн удирдлагууд ариутгах татуургын сүлжээнд MNS 6561:2015 стандартын шаардлагыг хангасан бохир усыг нийлүүлэхээ мэдэгдэв.

[Эх сурвалж: УСУГ-ын албан ёсны Фэйсбүүк хуудас](#)

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА



Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга Ж.Батсуурь нар Хамтран ажиллах санамж бичгийг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр байгуулж, үр дүнг тооцож ажиллахаар болжээ. Уг хамтран ажиллах санамж бичгийн зорилго нь Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль болон Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын холбогдох зорилтуудыг хангуулах, Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, Засгийн газрын 2019 оны 474, 2020 оны 211 дүгээр

тогтоолыг хэрэгжүүлэх, салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах чиглэлээр хамтран ажиллахад оршино.

[Эх сурвалж: Усны үйлчилгээг зохицуулах зөвлөл](#)

2030 УСНЫ НӨӨЦИЙН БҮЛГИЙН МОНГОЛ ДАХЬ ХӨТӨЛБӨРИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛДААН БОЛЛОО



Дэлхийн банкны дэргэдэх 2030 Усны нөөцийн бүлгийн Удирдах зөвлөлийн ээлжит хурал цахим хэлбэрээр зохион байгуулагдаж, БОАЖЯ-ны ТНБД Д.Ганболд оролцжээ. Тэрээр “БОАЖЯ нь УУХҮЯ, “2030 Усны нөөцийн бүлэг”-тэй хамтран Өмнөд говийн бүсийн усны эрэлтийг хангах боломжит хувилбаруудад гидро-экономикийн шинжилгээ хийж, сүүлийн жилүүдэд энэ бүс нутагт байгуулсан газрын доорх усны мониторингийн цооногуудын өгөдлийг боловсруулах, тэдгээрийн үр дүнг шийдвэр гаргахад ашиглах хяналт-удирдлагын динамик порталыг бий болгох ажлуудыг хийсэн. Монгол Улсын эдийн засгийг 2020-2024 онд хөгжүүлэх Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгаснаар

Говийн бүсэд төлөвлөж байгаа хүнд үйлдвэр, ялангуяа нүүрс боловсруулах, их чадлын цахилгаан станц байгуулах төслүүдийг урагшлуулахад одоо байгаа усны эх үүсвэрүүдийн боломжит нөөц нь эрэлтээ хангахгүй байгаа. Нөөцийг нэмэгдүүлэх хувилбаруудын хамгийн оновчтойг нь сонгон хэрэгжүүлэхэд дээрх ажил үр дүнгээ өгч байгаа юм” гэжээ. Тус хурлаар “2030 Усны нөөцийн бүлэг”-ийн Монгол дахь хөтөлбөрийн зохицуулагч Др.Д.Доржсүрэн 2020 оны үйл ажиллагааны үр дүнг танилцуулж, 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлэн батлуулжээ.

[Эх сурвалж: БОАЖЯ](#)

УЛААНБААТАР ХОТЫН УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ОЛОН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙГ УРАГШЛУУЛАХ НААШТАЙ ШИЙДВЭРҮҮД ГАРАВ



2021 оны 1 дүгээр сарын 20-ны Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын салбартай холбоотой хэд хэдэн чухал уулзалт болж, тус салбарт хэрэгжүүлэх олон төсөл, хөтөлбөрийг урагшлуулах нааштай шийдвэрүүд гарсан байна. Тодруулбал, АНУ-ын Мянганы Сорилтын корпорацын 350 сая ам.долларын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх Улаанбаатар хотын ус хангамжийг цогцоор сайжруулах, тогтвортой байдлыг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийслэл, салбарын яамд онцгой анхаарал хандуулж, хамтын ажиллагаагаа эрчимжүүлэхээр болсон байна. Түүнчлэн Дэлхийн банкны дэргэдэх “2030 усны нөөцийн бүлэг”-ийн 2021 онд хийх ажлын төлөвлөгөөнд Баянзүрх дүүргийн 17 дугаар хороо орчмын хөрсний ус болон

СЭМҮТ-ийн цэвэршүүлсэн усыг Амгалан дулааны станцад техникийн усны зорилгоор ашиглах талаар судалгаа хийх, Улаанбаатар хот орчмын газрын доорх усны мониторинг сүлжээ байгуулах зэрэг ажлуудыг тус тус багтаажээ.

[Эх сурвалж: УСУГ-ын албан ёсны Фэйсбүүк хуудас](#)